

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2017 оны 6 сарын 29-ны өдөр

Дугаар А-19/1-332

Улаанбаатар хот

Хамтарсан тушаалыг хүчингүй болгох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны А-60/78 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2017 оны 6 сарын 27 өдөр

Дугаар 4-185

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны гадаад гүйлгээний сарын тайлан гаргах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалыг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Ж.Батхуяг), Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т, энэ тушаалын 1 дэх хэсэгт заасан журмын дагуу банкнаас гадаад гүйлгээний тайланг батлагдсан журмын дагуу авч байхыг Судалгаа статистикийн газар (Д.Ган-Очир)-т тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН



Гадаад гүйлгээний сарын тайлан гаргах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Монгол Улсын гадаад секторын статистик үзүүлэлтийг тооцох ажлын хүрээнд банкнаас эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд хийсэн холбогдох гүйлгээний тайланг гаргах, Монголбанкнаас тайлангийн үнэн зөв байдлыг хянах, үнэлэх, бодит байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Тайланг зөвхөн Монгол Улсын гадаад секторын статистик үзүүлэлтийг тооцох, хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр, судалгаа шинжилгээнд статистик мэдээллийн зориулалтаар ашиглана.

Хоёр. Нэр томьёо

- 2.1 Энэхүү журамд тусгагдсан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ.
 - 2.1.1 “Эдийн засгийн харьяат” (цаашид “харьяат” гэх) гэдэгт:
 - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд,
 - Гадаад орнуудад нэг жил хүртэл хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд,
 - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нэг жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд,
 - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага ба тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар,
 - Монгол Улсаас гадаад оронд суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт,
 - Гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт болон богино хугацаагаар эмчлүүлж буй Монгол Улсын иргэд хамаарна.
 - 2.1.2 "Эдийн засгийн харьяат бус" (цаашид “харьяат бус” гэх) гэдэгт 2.1.1-т заасан ангилалд үл хамраарах гадаад орны болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг ойлгоно.
 - 2.1.3 “Гадаад гүйлгээний сарын тайлан” (цаашид “тайлан” гэх) гэдэгт тухайн сарын ажлын эхний өдрөөс сүүлийн өдрийн хооронд банк өөрийн болон харилцагчийн нэрийн өмнөөс харьяат болон харьяат бустай хийсэн холбогдох гүйлгээг хавсралтаар батлагдсан маягтуудын дагуу нэгтгэн гаргасан мэдээлэл хамаарна.
 - 2.1.4 “Гадаад гүйлгээ” гэдэгт Монгол Улсын харьяат банк болон харьяат бус банк хооронд НОСТРО дансаар шилжүүлэг хийж байгаа үйл ажиллагаа хамаарна.

- 2.1.5 “Дотоод гүйлгээ” гэдэгт Монгол Улсын харьяат банк дахь харьяат бус (оршин суугч бус)-ын тухайн банк дотор болон харьяат банк хооронд төгрөг, валютын бэлэн болон бэлэн бус шилжүүлэг хийх үйл ажиллагааг ойлгоно.
- 2.1.6 “Хяналтын үнэлгээний хуудас” гэж Монголбанкнаас тухайн банкны тайлангийн бүрэн, алдаагүй, үнэн зөв ирүүлсэн байдлыг хавсралтаар батлагдсан маягтын дагуу хянан шалгаж, үнэлсэн баримтыг хэлнэ.
- 2.1.7 “Зөвшөөрөгдөх босго утга” гэж мэдээллийн бүрэн бус байдал, техникийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалан үүсч хүлээн зөвшөөрөгдөх алдааны хэмжээг хэлнэ.
- 2.1.8 “Анхааруулга үнэлгээ” гэдэгт банк нь хяналтын үнэлгээний хуудас дахь тайлангийн үнэлгээний 4 шалгуураас 2-оос дээш үзүүлэлтийн босго утгыг хангаагүй эсхүл хяналтын үнэлгээний хуудсанд тэмдэглэсэн зөрчлийг нэг жилийн хугацаанд 3 удаа гаргасан тохиолдолд өгөх дүгнэлт үнэлгээ хамаарна.

Гурав. Тайлан гаргах

- 3.1 Тайланг энэ журмын Хавсралт 1-ээр батлагдсан дараах 3 маягтын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэд, алдаагүй гаргана.

Маягт 1. Гадаад гүйлгээний тайлан

- Харьяат харилцагчийн гадаад гүйлгээ,
- Харьяат бус (оршин суугч бус) харилцагчийн гадаад гүйлгээ,
- Банкны гадаад гүйлгээ.

Маягт 2. Харьяат бус (оршин суугч бус)-ын дотоод гүйлгээний тайлан

- Харьяат бусын (оршин суугч бус)-ын харилцах, хадгаламжийн дансны дотоод гүйлгээ,
Жишээ нь: оршин суугч бус гэдэгт олон улсын байгууллага (НҮБ, ОУВС, АХБ, Дэлхийн банк, г.м), Гадаад орнуудаас Монгол улсад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчийн газар, Гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын салбар, төлөөлөгчийн газар (гадаадын агаарын тээврийн компаниуд г.м) орно.

Маягт 3. Хяналтын тайлан

- Банкны Монголбанкин дахь ТӨГРӨГ/ВАЛЮТ,
- Банкны бусад банк дахь ТӨГРӨГ/ВАЛЮТ,
- Банк дахь бусад банкны ТӨГРӨГ/ВАЛЮТ болон ЛОРО дансаар хийгдсэн арилжаа, зузаатгал.

- 3.2 Тайлангийн бүрэлдэхүүн:

- *Тайлангийн формат.* “Times New Roman” фонтоор, 10pt үсгийн хэмжээг сонгон бичнэ.
- *Гүйлгээний дугаар.* Тайлант сард хийгдсэн бүх гүйлгээг 1-ээс эхлэн дугаарлана.
- *Гүйлгээ хийгдсэн огноо.* Гүйлгээ хийгдсэн огноог сар/өдөр/он гэсэн дарааллаар, “Short date” форматаар бичнэ.
- *Регистрийн дугаар.* Маягт 1-т төлбөр хүлээн авагч эсхүл шилжүүлэгч харьяат аж ахуйн нэгж, иргэний, харин Маягт 2-т төлбөр хүлээн авагч эсхүл шилжүүлэгч харьяат бус аж ахуйн нэгж,

- иргэний регистрийн дугаарыг тус тус бичнэ. ААНБ-ын ажил гүйлгээг төлбөр шилжүүлэгч, хүлээн авагч иргэний бус заавал тухайн байгууллагын өөрийн регистрийг бичнэ.
- *Төлбөр шилжүүлэгч.* Гүйлгээ хийж байгаа байгууллага, хувь хүний нэрийг бичнэ.
 - *Төлбөр хүлээн авагч.* Гүйлгээг хүлээн авч байгаа байгууллага, хувь хүний нэрийг бичнэ.
 - *Гүйлгээний код.* Гүйлгээний төлбөрийн баримтад бичсэн утгыг үндэслэн гүйлгээ тус бүрт Хавсралт 2-т заасны дагуу харгалзах кодыг онооно.
 - *Гүйлгээний зориулалт.* Гүйлгээний төлбөрийн баримтад бичсэн утгыг оруулна¹.
 - *Дансны төрөл.* Гүйлгээг хүлээн авч байгаа болон шилжүүлж байгаа харьяат ААН, иргэний дансны эзэмшиж буй валютыг бичнэ.
 - *Валют.* Гүйлгээ хийсэн валютын кодыг ISO 4217 стандартын дагуу тэмдэглэнэ.
 - *Гүйлгээний дүн: үндсэн валютаар.* Гүйлгээг хийсэн валютын дүнг мянгачлан оруулна.
 - *Гүйлгээний дүн: ам.доллараар.* Ам.доллараас бусад валютаар хийсэн гүйлгээг тухайн гүйлгээг хийсэн өдөр мөрдөгдөх Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах ханшаар ам.долларт хөрвүүлсэн дүнг мянгачлан оруулна.
 - *Гүйлгээнд оролцогч эсрэг талын улсын код.* Гүйлгээнд оролцогч эсрэг талын харьяалагдах улсын кодыг оруулахдаа Хавсралт 4-ийг ашиглах ба тусгайлан кодлогдоогүй орнуудыг оршин байгаа тивийг харгалзан бусад орнууд гэсэн тэмдэглэлийг ашиглан кодолно.

Дөрөв. Тайлан хүргүүлэх

- 4.1 Банк нь тайлангийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах үүрэг бүхий хоёроос доошгүй ажилтан, тайланг баталгаажуулах захирал эсхүл ахлах мэргэжилтний нэр, албан тушаал, цахим хаяг, холбоо барих утасны дугаарыг албан ёсоор Монголбанкинд хүргүүлж, тэдгээрт өөрчлөлт гарах нөхцөлд тухай бүр мэдэгдэнэ.
- 4.2 Монголбанк энэ журмын 4.1-д заасан мэдээллийг хүлээн авч, мэдээллийн сан үүсгэн Монголбанкны Банкны тайлангийн системд нэвтрэх хэрэглэгчийн эрх, нууц үгийг банкинд олгоно.
- 4.3 Банк нь тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор Банкны тайлангийн системээр хүргүүлэх бөгөөд уг систем ажиллахгүй саатсан тохиолдолд баталгаажсан цахим хаягаас Монголбанкны статистикийг боловсруулж, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч газар, хэлтсийн баталгаажсан цахим хаягаар хүргүүлнэ.
- 4.4 Банк нь Монголбанкнаас хүссэн тайлангийн тодруулга, лавлагааны хариу тайлбар, нэмэлт мэдээллийг ажлын 1 өдрийн дотор утсаар эсхүл цахим шуудангаар, шаардлагатай тохиолдолд албан бичгээр хүргүүлж, статистик үзүүлэлтийн үнэн бодит байдлыг хангахад хамтран ажиллана.

Тав. Тайлангийн хяналт

- 5.1 Монголбанк нь банкнаас хүлээн авсан тайлангийн мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, алдаагүй бөглөн ирүүлсэн эсэхийг хянах ажлын хүрээнд банкнаас тодруулга, мэдээллийг авах бөгөөд шаардлагатай тохиолдолд гүйлгээний баримтын хуулбарыг гаргуулан авна.

¹ 200,000 (хоёр зуун мянга) ам.доллараас дээш дүнтэй гүйлгээний зориулалтыг тухайн гүйлгээг үнэн зөв кодлоход хангалттай хэмжээний мэдээлэл оруулна.

- 5.2 Монголбанкны статистик хариуцсан ажилтнууд нь 5.1-т заасны дагуу хүлээн авсан болон холбогдох бусад мэдээлэлд үндэслэн тайлангийн бүрэлдэхүүний мэдээллийг хянаж, аливаа алдаатай мэдээллийг залруулан бүртгэнэ.
- 5.3 Монголбанкны тайлан хариуцсан ажилтан нь 4.3-т заасны дагуу хүлээн авсан тайлангийн мэдээллийг 5.2-т заасны дагуу хянан залруулсан тайлангийн мэдээлэлтэй харьцуулж, аливаа зөрүүтэй мэдээллийн тоо хэмжээг хяналтын үнэлгээний хуудасны харгалзах шалгуур үзүүлэлтэд хувь (%) -иар илэрхийлэн тэмдэглэнэ.
- 5.4 Хяналтын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, хүлээн зөвшөөрөгдөх босго утга:
- *Гүйлгээ бүрэн байх.* Гүйлгээг дутуу оруулсан байх нь статистик, судалгааны чанарт сөргөөр нөлөөлөх ноцтой зөрчил тул хүлээн зөвшөөрөгдөх босго утга 1 (нэг) сая ам.доллар байна.
 - *Тайлангийн бүрэлдэхүүний мэдээлэл бүрэн байх.* Гүйлгээний мэдээлэл дутуу оруулсан байх нь гүйлгээг зөв кодлох, эдийн засгийн салбараар ангилахад сөргөөр нөлөөлөх зөрчил тул хүлээн зөвшөөрөгдөх босго утга 200,000 (хоёр зуун мянга) ам.доллараас дээш дүнтэй нийт гүйлгээний 2%, бусад гүйлгээний 5% байна.
 - *Тайлангийн бүрэлдэхүүний мэдээлэл үнэн зөв байх.* Гүйлгээний мэдээлэл алдаатай байх нь судалгаа шинжилгээ, бусад хяналт шалгалтыг хийхэд сөргөөр нөлөөлөх зөрчил тул хүлээн зөвшөөрөгдөх босго утга 200,000 (хоёр зуун мянга) ам.доллараас дээш дүнтэй нийт гүйлгээний 5%, бусад гүйлгээний 15% байна.
 - *Техникийн алдаагүй байх.* Тайлангийн формат зөрүүтэй, гүйлгээний дүнг мянгачлаагүй, кредит, дебитын баганыг сольсон зэрэг санамсаргүй гаргасан алдаа нь тайланг нэгтгэн боловсруулахад сөргөөр нөлөөлдөг тул шууд зөрчилд тооцно.
 - *Гүйлгээний код зөв байх.* Гүйлгээний зориулалт болон бусад мэдээлэлд үндэслэн гүйлгээг зөв кодлох нь статистикийг үнэн, бодитой гаргахад чухал ач холбогдолтой. Хүлээн зөвшөөрөгдөх босго утга 200,000 (хоёр зуун мянган) ам.доллараас дээш дүнтэй нийт гүйлгээний 5%, бусад гүйлгээний 10% байна.
- 5.5 Монголбанк нь хяналтын үнэлгээний хуудсыг цахим шуудангаар, шаардлагатай гэж үзвэл албан бичгээр мэдэгдэж, банк нь дахин зөрчил гаргахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор 5.2-т заасны дагуу хянан залруулсан тайланг хүргүүлж болно.
- 5.6 Банкны тайлангийн хяналтын үнэлгээс шалтгаалан Монголбанк хяналтын давтамжийг тодорхойлох бөгөөд шаардлагатай тохиолдолд өмнөх саруудын тайланд хяналтын үнэлгээг нөхөн хийнэ.
- 5.7 Монголбанкны ажилтан дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- Тайлангийн мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах,
 - Байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцыг чандлан хадгалах,
 - Банкнаас гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээллийг тодруулах, гаргуулж авах,
 - Банкнаас хяналтын үнэлгээний хуудсанд тусгагдсан зөрчлийг арилгах, энэ журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, хугацаатай үүрэг даалгавар өгөх.

5.8 Банкны ажилтан дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Тайлангийн үнэн зөв, бодит байдлыг бүрэн хариуцах,
- Монголбанкны тодруулга, шаардсан баримт, материалыг тухай бүр тогтоосон хугацаанд нь гаргаж хүргүүлэх,
- Тайлангийн хяналтын үнэлгээтэй холбоотой тайлбар, саналаа Монголбанкинд хүргүүлэх, зөвшилцөх.

Зургаа. Хариуцлага

6.1 Энэ журмын 4-т заасны дагуу хүргүүлсэн тайлан, мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн банк хариуцна.

6.2 Монголбанк нь энэ журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй банкинд дараах арга хэмжээг авна.

6.2.1 Банкинд хяналтын үнэлгээний хуудсыг цахим шуудангаар илгээх, хэрэв анхааруулга үнэлгээ авсан тохиолдолд албан бичгээр хүргүүлэх.

6.2.2 Банк нь 2 удаа анхааруулга үнэлгээ авсан тохиолдолд Монголбанк нь Банкны тухай хууль, Статистикийн тухай хууль Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг банкинд ногдуулах.

6.3 Монголбанк нь мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

Долоо. Хамтын ажиллагаа

7.1 Монголбанк нь банкны тайлан хариуцсан ажилтнуудад зориулан гадаад гүйлгээний тайлан гаргах чиглэлээр мэдээлэл өгөх уулзалт, сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

7.2 Банк нь тайлан хариуцсан ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтнууд өөрчлөгдөх тохиолдолд тэднийг дотооддоо сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас сургалт авах хүсэлтийг гарган шийдвэрлүүлнэ.

7.3 Тайлан гаргах, хянах ажлыг оновчтой, үр дүнтэй болгох болон статистик судалгааны үзүүлэлтийн тооцооллыг сайжруулах чиглэлээр санал солилцох, зөвшилцөх, шаардлагатай гэж үзвэл журамд өөрчлөлт оруулна.

7.4 Банк нь энэ журамтай холбоотойгоор аливаа тодруулга, лавлагааг Монголбанкны статистикийг боловсруулж, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч газар, хэлтсээс албан бичиг, цахим шуудах болон утсаар холбогдон авч болно.

----- оОо -----

Гадаад гүйлгээний сарын тайлан
гаргах журмын Хавсралт №1

МАЯГТ 1. Гадаад гүйлгээний тайлан

Монголбанк	Банкны нэр:
Гадаад гүйлгээний тайлан	Тайлант сар:
	Тайлан гаргасан огноо:

Дугаар	Гүйлгээ хийгдсэн сар/өдөр/он	Гүйлгээний код	Регистрийн дугаар	Толбор шилжүүлэгч	Толбор хүлээн авагч	Дансны төрөл	Гүйлгээний зориулалт	Валют	Үндсэн валютгаар		Ам.доллараар		Гүйлгээнд оролцогч эсрэг талын улсын код
									Кредит	Дебит	Кредит	Дебит	

Гадаад гүйлгээний тайлант гаргасан:

Хянасан:

TAMGA

Боловруулсан:

МАЯГТ 2. Харьяат бусын дотоод гүйлгээний тайлан

Монголбанк	Банкны нэр:
Харьяат бусын дотоод гүйлгээний тайлан	Тайлант сар:
	Тайлан гаргасан огноо:

Дугаар	Гүйлгээ хийгдсэн сар/өдөр/он	Гүйлгээний код	Регистрийн дугаар	Толбор шилжүүлэгч	Толбор хүлээн авагч	Дансны төрөл	Гүйлгээний зориулалт	Валют	Үндсэн валютгаар		Ам.доллараар		Гүйлгээнд оролцогч эсрэг талын улсын код
									Кредит	Дебит	Кредит	Дебит	

Гадаад гүйлгээний тайлант гаргасан:

Хянасан:

TAMGA

Боловруулсан:

МАЯГТ 3. Хяналтын тайлан

Монголбанк	Банкны нэр:
Энэхүү тайлан нь хяналт, шалгалтад зориулагдсан нэмэлт мэдээллийг агуулна. Үүнд зөвхөн: Арилжаа, Зузаатгал, Гадаад валютын хэлэлцээр гэх зэрэг хамаарна.	Тайлант сар:
Хяналтын тайлан	Тайлан гаргасан огноо:

Дугаар	Гүйлгээ хийгдсэн сар/өдөр/он	Гүйлгээний код	Гүйлгээ шилжүүлсэн данс	Гүйлгээ хүлээн авсан данс	Дансны төрөл	Гүйлгээний зориулалт	Валют	Үндсэн валютгаар		Гүйлгээнд оролцогч эсрэг талын улсын код
								Кредит	Дебит	

Гадаад гүйлгээний тайлант гаргасан:

Хянасан:

TAMGA

Боловруулсан:

Гадаад гүйлгээний сарын тайлан
гаргах журмын **Хавсралт №2**

ГҮЙЛГЭЭНИЙ КОД

Данс	Гүйлгээний код		Тайлбар
	Кредит	Дебит	
I. УРСГАЛ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ			Урсгал данс нь эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн бараа, үйлчилгээ, анхдагч болон хоёрдогч орлогын гүйлгээг харуулна.
A. БАРАА			Монгол Улсын хилээр нэвтрүүлж, эзэмшигчийн өмчлөх эрх шилжих бүх төрлийн биет бараа бүтээгдэхүүний төлбөрийн орлого, зардлын гүйлгээг бүртгэнэ.
1. Экспорт			Харьятаас харьяат бус руу нийлүүлсэн экспортын бараатай холбоотой хүлээн авсан орлогыг бүртгэнэ.
1.1 Ноолуур, ноолууран бүтээгдэхүүн	1111		Боловсруулсан, түүхий болон самнасан ноолуур, ноолууран бүтээгдэхүүн.
1.2 Мал аж ахуй, Хөдөө аж ахуйн түүхий эд	1112		Малын арьс шир, өлөн гэдэс, мах, ноос зэрэг малын гаралтай бүтээгдэхүүн, үр тариа, самар, рапс зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд.
1.3 Зэсийн баяжмал	1113		Зэсийн баяжмал, катод, зэсийн бусад бүтээгдэхүүн.
1.4 Аж үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн	1114		Тоног төхөөрөмж, гэр, нэхмэл эдлэл, хивс, эм, гар урлалын бүтээгдэхүүн зэрэг бүрэн боловсруулалт хийгдэж, эцсийн хэрэглэгч хэрэглэхэд бэлэн болсон бүтээгдэхүүний орлого.
1.5 Нүүрс	1115		Түүхий, угаасан болон коксжих нүүрс.
1.6 Нефтийн бүтээгдэхүүн	1116		Түүхий нефтийн экспорт болон Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцонд олгосон түлш шатахуун.
1.7 Төмрийн хүдэр	1117		Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалын орлого.
1.8 Бусад эрдэс бүтээгдэхүүн	1118		Хайлуур жонш, цайр, цайрын баяжмал зэрэг дээрх ангилалд үл хамаарах бусад ашигт малтмалын экспортын орлогыг бүртгэнэ.
1.9 Бусад	1119		Дээрх ангиллуудад үл хамаарах бүтээгдэхүүний экспортын орлогыг бүртгэнэ.
2. Импорт			Харьяатын харьяат бусаас хүлээн авсан импортын бараатай холбоотой шилжүүлсэн төлбөрийг бүртгэнэ.
2.1 Хүнсний бараа бүтээгдэхүүн		2111	Бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, тэдгээрийн үйлдвэрлэлд хэрэглэгдэх элсэн чихэр, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, амт оруулагч, гурил зэрэг түүхий эдийг худалдан авахаар шилжүүлсэн төлбөр.
2.2 Бусад түргэн эдэлгээтэй хэрэглээний бараа		2112	Гоо сайхны бараа, батерей, эм, зүү тариур, амны цаас, ариун цэврийн хэрэглэл, хуванцар эдлэл, тамхи зэрэг хүмүүсийн өдөр тутам хэрэглэдэг, богино хугацаанд хэрэглэгдээд дуусдаг хэрэглээний барааны төлбөр.
2.3 Машин механик, тоног төхөөрөмж		2113	Үйлдвэрлэлийн орцын шинж чанарыг өөрчлөхөд ашиглагддаг бүх төрлийн тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг хэрэгслийн төлбөр.
2.4 Суудлын автомашин, сэлбэг хэрэгсэл		2114	Суудлын машин, автобус, дугуй, мотоцикл, мопед зэрэг тээврийн хэрэгслүүд (хүнд даацын машин, тоног төхөөрөмжөөс бусад), тэдгээрийн сэлбэг хэрэгслийн төлбөр.
2.5 Нефтийн бүтээгдэхүүн		2115	Нефтийн гаралтай бензин, хийн болон дизел түлш, моторын тос, бусад тосолгооны материалын төлбөр.

2.6 Бусад удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн		2116	Гутал хувцас, компьютер, гар утас, гэр ахуйн тавилга, бүх төрлийн цахилгаан бараа, ахуйн зориулалттай телевизийн ангиен зэрэг хүмүүсийн өдөр тутам хэрэглэдэг, удаан эдэлгээтэй барааны төлбөр.
2.7 Барилгын материал		2117	Цемент, битүмен, барилгын гадаад, дотоод засал чимэглэлийн материалууд, цахилгаан шат, цахилгаан болон холбооны утас зэрэг барилга барихад шаардагдах бүх төрлийн материалын төлбөр.
2.8 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний орц		2118	Эцсийн болон завсарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглагдах даавуу, утас, шошго, архины шил, тээсэлгээний материал, төмөр бөмбөлөг, хуванцар бэлдэц зэрэг үйлдвэрлэлийн түүхий эдийн төлбөр.
2.9 Бусад		2119	Дээрх ангилалд үл хамаарах бараа бүтээгдэхүүний импортын төлбөр.
Б. ҮЙЛЧИЛГЭЭ			Харьяатын харьяат буст үзүүлсэн үйлчилгээний орлогын гүйлгээг кредит, харьяат бусаас авсан үйлчилгээний зардлын гүйлгээг дебит талд бүртгэнэ.
1. Тээврийн үйлчилгээ			Бүх төрлийн тээврийн хэрэгслээр хийгдсэн зорчигч, тээш, ачаа болон шуудан тээвэрлэлт болон бусад туслах ажил, үйлчилгээ.
1.1 Ачаа тээвэр	1211	2211	Агаарын болон газрын ачаа тээвэрлэлт, холбогдох туслах ажил, үйлчилгээ.
1.2 Зорчигч тээвэр	1212	2212	Агаарын болон газрын зорчигч тээвэр (онгоц, галт тэрэгний тасалбарын үнэ)-ийн үйлчилгээ.
1.3 Бусад тээвэр	1213	2213	Навигацийн төлбөр болон шуудан хүргэлт, ачаа ачих, буулгах, ялгах, зуучлах, хадгалах зэрэг тээвэрлэлтэд бэлтгэх, тээвэрлэлийг дуусгавар болгохтой холбоотой туслах ажил, үйлчилгээ.
2. Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ			Харьяат (харьяат бус) даатгал, тээврийн байгууллагаас харьяат буст (харьяат) үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээний төлбөрийн гүйлгээ.
2.1 Шууд даатгалын үйлчилгээ			Амь нас, эд хөрөнгө, хариуцлагын болон бусад даатгалын хураамж, түүний нөхөн төлбөр.
2.1.1 Хураамж	1221	2221	Байгууллага, иргэдийн даатгалын компанид төлөн хураамж.
2.1.2 Нөхөн төлбөр	1222	2222	Байгууллага, иргэдийн даатгалын компаниас авсан нөхөн төлбөр.
2.2 Давхар даатгалын үйлчилгээ	1223	2223	Даатгалын компани хооронд хийгдсэн давхар даатгалын үйлчилгээний хураамж, нөхөн төлбөр.
2.3 Тэтгэврийн даатгалын үйлчилгээ	1224	2224	Тэтгэврийн даатгалын шимтгэл, тэтгэвэр олголт.
3. Аялал жуулчлал			Аялагчийг аяллын зорилгоос нь хамааруулан жуулчлал, эмчилгээ, сургалт, бусад гэж ангилах ба аялах хугацаандаа хувийн хэрэгцээндээ, бусад бэлэглэх зорилгоор худалдан авсан бараа, үйлчилгээний төлбөрийн гүйлгээ.
3.1 Жуулчлал	1225	2225	Жуулчлах зорилгоор аялж буй аялагчийн аяллын хугацаанд худалдан авсан бараа, үйлчилгээний төлбөр (байр, хоол, орон нутгийн тээвэр, үзвэр, бусад үйлчилгээ). Үүнд: Master card, Union pay, Visa card, American express гэх мэт данс эзэмшдэг тусгай үйлчилгээгээр шилжүүлсэн дүн болон гүйлгээний утга тодорхойгүй багц төлбөрүүд мөн хамаарна.
3.2 Эмчилгээ	1226	2226	Эмчлүүлэгчийн эмчлүүлэх хугацаандаа авсан бараа, үйлчилгээний төлбөр (эмчилгээ, үзлэг, оношилгоо, байр, хоол, бусад төлбөр).
3.3 Сургалт	1227	2227	Суралцагчийн суралцах хугацаанд авсан бараа, үйлчилгээний төлбөр (сургалтын төлбөр, байр, хоол, холбогдон гарсан бусад төлбөр).

3.4 Бусад	1228	2228	Албан зорилгоор аялж буй(хурал зөвлөгөөн, уулзалт, туршлага судлах г.м) зорчигчийн аялын хугацаанд авсан бараа, үйлчилгээний төлбөр.
4. Барилгын үйлчилгээ	1230	2230	Барилга угсралт, түүний засвар, барилгын төслийн удирдлагын болон холбогдох бусад үйлчилгээ.
5. Санхүүгийн үйлчилгээ	1231	2231	Банк, санхүүгийн байгууллагуудын үзүүлж буй зээл, аккредитив, лизинг, харилцах, хадгаламж, валютын арилжаа болон брокер, диллер зэрэг санхүүгийн зуучлалын үйлчилгээний төлбөр, шимтгэлүүд.
6. Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр	1232	2232	Патент, барааны тэмдэг, утга зохиол (ном, роман тууж, шүлэг г.м), уран сайхны бүтээл (кино, хөгжмийн бүтээл, уран зураг, гэрэл зураг г.м)-ийн зохиогчийн эрхийг ашиглах (хуулбарлах, нийтлэх, нийтэд түгээх г.м)-тай холбогдсон төлбөр.
7. Харилцаа холбооны үйлчилгээ	1233	2233	Дуу, дүрс, өгөгдөл болон бусад мэдээллийг нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авахтай холбоотой цахилгаан холбоо, радио, телевиз, мэдээллийн технологийн бүх төрөл (сансрын хиймэл дагуул, интернет, роуминг, свифт, ройтерс, блүмберг)-ийн сүлжээ ашиглалтын үйлчилгээ.
8. Компьютер ба мэдээллийн үйлчилгээ	1234	2234	Компьютерын программ-техник хангамжтай холбоотой программын лицензийн борлуулалт, программын хөгжүүлэлт, үйлдвэрлэл, засвар болон зөвлөгөө өгөх үйлчилгээ багтана. Мэдээллийн агентлагын болон мэдээ, нэвтрүүлэг бэлтгэх, мэдээллийн сан, интернет хайлтын системийг ашиглах, номын сан, архивын зэрэг бусад үйлчилгээ.
9. Судалгаа, хөгжүүлэлтийн үйлчилгээ	1235	2235	Судалгаа, шинэ бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн туршилт, дэвшилтэд технологийн хөгжүүлэлттэй холбогдон гарч буй үйлчилгээний төлбөрийг хамааруулна.
10. Мэргэжлийн болон бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээ	1236	2236	Нягтлан бодох бүртгэл, аудит, татвар, хууль зүйн, зар сурталчилгаа, зах зээлийн судалгаа болон байгууллагын бизнесийн ерөнхий удирдлагын зөвлөх үйлчилгээ.
11. Техникийн, худалдааны болон бизнесийн бусад үйлчилгээ	1237	2237	Архитектур, инженер, техник, хөдөө аж ахуй, уул уурхай (хайгуул, өрөмдлөг, олборлолт), хог хаягдлыг боловсруулах, байгаль орчин нөхөн сэргээх болон үйл ажиллагааны түрээсийн үйлчилгээ.
12. Хувийн, соёлын, амралт чөлөөт цагийн үйлчилгээ	1238	2238	Радио, телевизийн программ, дуу, дүрс бичлэгийн үйлчилгээ, алсын зайн эрүүл мэнд (эмнэлэг, лабаротор, эмч, сувилагч, эм зүйчийн үзүүлсэн), боловсрол (интернет сургалт)-ын үйлчилгээ.
13. Засгийн газрын бараа, үйлчилгээ	1239	2239	Элчин сайдын яам, олон улсын байгууллага, цэргийн баазад болон дипломатууд, консулын ажилчид, цэргийн албан хаагчид, тэдний гэр бүлийнхний харьяат/харьяат бусын нутаг дэвсгэр дээрээс авсан бараа үйлчилгээний төлбөр.
14. Нэмэлт боловсруулалт хийлгэх үйлчилгээ	1240	2240	Бусдын эзэмшлийн бараа, бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийх (угсралт, шошголох, савлах, баглаа боодол, нэмэлт боловсруулалтын үйлдвэрлэл) үйлчилгээний төлбөр.
15. Засвар, үйлчилгээ	1241	2241	Бусдын эзэмшлийн бараа, бүтээгдэхүүнд хийх засвар үйлчилгээ (харьяат-харьяат бус) нь засварлагчийн нутаг дэвсгэр дээр явагдаж болох ба агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төлбөр.
16. Бусад үйлчилгээ	1250	2250	Дээрх ангиллуудад үл хамаарах бусад төрлийн үйлчилгээний төлбөр.

В. АНХДАГЧ ОРЛОГО			Харьяат болон харьяат бус хооронд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцох, санхүүгийн хөрөнгө эзэмших, байгалийн баялгийг түрээслэх холбогдох орлогыг бүртгэнэ.
1. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	1311	2311	Харьяатын харьяат бусаас авсан хөдөлмөрийн хөлс (цалин хөлс, даатгал, бусад төлбөр)-ийг кредит, харьяат бус төлсөн дүнг дебит талд бүртгэнэ.
2. Ногдол ашиг	1312	2312	Хувь нийлүүлсэн үйлдвэр, аж ахуйн газарт оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр, тэдгээрийн үйл ажиллагааны эцсийн үр дүнгээс хувьцаа эзэмшигчдийн авах ногдол ашгийн орлогыг бүртгэнэ. Харьяатын харьяат бусаас хүлээн авсан орлогыг кредит, харьяат бус руу шилжүүлсэн орлогыг дебит талд бүртгэнэ.
3. Бүх төрлийн үнэт цаасны хүү	1313	2313	Бүх төрлийн үнэт цаас (бонд, өрийн бичиг)-ны хүүгийн төлбөртэй холбоотой гүйлгээ буюу харьяат бусаас хүлээн авсан хүүгийн орлогыг кредит, харьяат бус руу төлсөн хүүгийн зардлыг дебит талд бүртгэнэ.
4. Зээлийн хүү	1314	2314	Харьяатын харьяат бусаас хүлээн авсан зээлийн хүүгийн орлогыг кредит, харьяат бус руу төлсөн зээлийн хүүгийн төлбөрийг дебит талд бүртгэнэ.
5. Хадгаламжийн хүү	1315	2315	Харьяатын гадаадын банкинд байршуулсан хариуцах, хадгаламжийн хөрөнгөөс хүлээн авсан хүүгийн орлогыг кредит, харьяат банкнаас харьяат бусын хадгаламжийн хөрөнгөд төлсөн хүүгийн зардлыг дебит талд бүртгэнэ.
6. Бусад	1316	2316	Дээрх ангиллуудад үл хамаарах бусад анхдагч орлогыг бүртгэнэ. Үүнд, байгалийн нөөц (ашигт малтмал, загасчлал, ойн аж ахуй, бэлчээр г.м) ашигласны төлбөр, бараа, үйлчилгээний татвар, татаас түүнтэй адилтгах орлого хамаарна.
Г. ХОЁРДОГЧ ОРЛОГО			Хоёрдогч орлогын данс нь харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн урсгал шилжүүлэг (ямар нэг харуу төлбөр авахгүйгээр өгч байгаа бараа, үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус актив)-ын гүйлгээг харуулна.
1. Засгийн газрын албан ёсны шилжүүлэг	1411	2411	Байгалийн болон бусад гамшгийг даван туулах, төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалтаар хүлээн авсан/ олгосон мөнгөн тусламж, ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн татвар/шилжүүлэг, техник тусламжааны хүрээнд ажиллагчдын цалин хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл, нөхөн олговор, хөдөлмөр, санхүүгийн хөрөнгөөс олсон ашиг орлогод ногдуулсан бүх төрлийн татвар болон засгийн газраас олгож буй тусгай зөвшөөрөл, лицензийн хураамж, татварыг цаг хугацаанд нь төлөөгүйтэй холбогдох торгуулийг уг дансанд бүртгэнэ.
2. Хувийн гуйвуулга	1412	2412	Харьяатын гадаадад ажиллаж амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын орлогыг кредит, гадагш шилжүүлсэн гуйвуулгын зардлыг дебит талд бүртгэнэ. Үүнд: Moneygram, Western Union, Faster гэх мэт зөвхөн гуйвуулга хийдэг тусгай үйлчилгээгээр шилжүүлсэн шилжүүлгүүд мөн орно.
3. Бусад салбарын хандив, тусламж	1414	2414	Улаан загалмай, шашны болон сайн дурын, урлаг соёлын зэрэг ТББ-ын шугамаар байгалийн болон бусад гамшгийг даван туулах зориулалтаар, хүмүүнлэгийн чанартай хүлээн авсан бүх төрлийн хандив, тусламжийн орлогыг кредит, гадаадад олгосон хандивыг дебит талд бүртгэнэ.
4. Бусад	1415	2415	Ан агнах, загас барих эрхийн хураамжийн төлбөр, спорт, урлагийн болон бусад тэмцээн уралдааны шагнал, сугалааны хонжвор, бусад ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамжийн орлого зэргийг бүртгэнэ.

II. ХӨРӨНГИЙН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ			Энэ дансанд харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус активын шилжүүлгийн гүйлгээг бүртгэнэ.
1. Хөрөнгийн шилжүүлэг	1501	2501	Эд хөрөнгө (бэлэн мөнгө, бараанаас бусад)-ийн өмчлөх эрх шилжсэн, өр төлбөрийг хүчингүй болгосон, ОУ-ын ба ашгийн бус байгууллагад хөрөнгө оруулсан болон хөрөнгө оруулалтын шинжтэй хандив, тусламж, өв залгамжлал, том хэмжээний бэлэг, шилжин суугчдын хөрөнгө, бусад хөрөнгийн шилжүүлэгт ногдсон татвар, шимтгэлийн орлого.
2. Газар, үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бус актив хөрөнгийн эзэмшил/шилжүүлэг	1502	2502	Байгалийн нөөцийг эзэмших эрхийг олж авах буюу элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжсэн газрын төлбөрийн орлогыг кредит, зардлыг дебит талд, түүнчлэн үйлдвэрлэдэггүй санхүүгийн бус хөрөнгө (худалдааны тэмдэг, зохиогчийн эрх, патент г.м)-ийг эзэмших эрхийн орлогыг кредит, зардлыг дебит талд тус тус бүртгэнэ.
III. САНХҮҮГИЙН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ			Санхүүгийн дансны гүйлгээг шууд хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалт, санхүүгийн үүсмэл хэрэгсэл, бусад хөрөнгө оруулалт гэсэн 4 дэд ангиллаар бүртгэнэ.
A. ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			Аж ахуйн нэгжийн удирдлагад нөлөө үзүүлэхүйц хэмжээ (энгийн эсхүл санал өгөх эрхийн хувьцааны 10%-аас дээш)-г эзэмшигч шууд хөрөнгө оруулагчийн тухайн аж ахуйн нэгжтэй хийсэн хөрөнгө оруулалтын гүйлгээг харуулна.
<i>1. Актив</i>			<i>Монгол улсаас гадаад улс руу хийсэн хөрөнгө оруулалт.</i>
1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1510	2510	Харьяат шууд хөрөнгө оруулагчийн харьяат бус аж ахуйн нэгжид хийсэн хөрөнгө оруулалтыг дебит, буцаан татсан хөрөнгийг кредит талд бүртгэнэ.
1.2 Өрийн хэрэгсэл	1511	2511	Харьяат шууд хөрөнгө оруулагчийн харьяат бус аж ахуйн нэгжид олгосон зээлийг дебит, буцаан төлөгдсөн зээлийг кредит талд бүртгэнэ.
1.3 Газар худалдан авах, зарах	1512	2512	Харьяат нь гадаад улсад газар, үл хөдлөх хөрөнгө худалдан авахаар төлбөрийг харьяат бус руу шилжүүлсэн бол дебит, буцаан зарснаар хүлээн авсан орлогыг кредит талд бүртгэнэ.
<i>2. Пассив</i>			<i>Гадаад улсаас Монгол улсад оруулсан хөрөнгө оруулалт.</i>
2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1520	2520	Харьяат бус шууд хөрөнгө оруулагчийн харьяат аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтыг кредит, буцаан татсан хөрөнгийг дебит талд бүртгэнэ.
2.2 Өрийн хэрэгсэл	1521	2521	Харьяат бус шууд хөрөнгө оруулагчийн харьяат аж ахуйн нэгжид олгосон зээлийг кредит, эргэн төлсөн зээлийг дебит талд бүртгэнэ.
2.3 Газар худалдан авсан/зарсан	1522	2522	Харьяат бус нь Монгол улсад газар, үл хөдлөх хөрөнгө худалдан авахаар төлбөрийг харьяат хүлээн авсан бол кредит, эргэн зарснаар буцаан шилжүүлсэн төлбөрийг дебит талд бүртгэнэ.
B. БАГЦЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			Хувьцаа (10% -аас бага), бонд, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэнэ.
<i>1. Актив</i>			
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1611	2611	Харьяат нь харьяат бус компанид багцын хөрөнгө оруулалт хийсэн бол дебит, хөрөнгө оруулалтаа буцаан татсан бол кредит талд бүртгэнэ.
Урт хугацаат үнэт цаас	1612	2612	Харьяат нь харьяат бусын гаргасан урт хугацаат үнэт цаас (бонд, өрийн бичиг)-ийг худалдан авсан бол дебит, буцаан худалдсан бол кредит талд бүртгэнэ.

Богино хугацаат үнэт цаас	1613	2613	Харьяат нь харьяат бусын гаргасан богино хугацаат үнэт цаасийг худалдан авсан бол дебит, буцаан худалдсан бол кредит талд бүртгэнэ.
<i>2. Пассив</i>			
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1621	2621	Харьяат бус нь харьяат компанид багцын хөрөнгө оруулалт хийсэн бол кредит, хөрөнгө оруулалтаа буцаан татсан бол дебит талд бүртгэнэ.
Урт хугацаат үнэт цаас	1622	2622	Харьяат бус нь харьяатын гаргасан урт хугацаат үнэн цаас (бонд, өрийн бичиг)-ийг худалдан авсан бол кредит, эргэн худалдсан бол дебит талд бүртгэнэ.
Богино хугацаат үнэт цаас	1623	2623	Харьяат бус нь харьяатын гаргасан богино хугацаат үнэт цаасыг худалдан авсан бол кредит, эргэн худалдсан бол дебит талд бүртгэнэ.
В. БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			
<i>1. Актив</i>			
1.1 Урт хугацаат зээл	1711	2711	Харьяатын харьяат буст 1 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгосон зээлийг дебит, буцаан төлөгдөж буй зээлийг кредит талд бүртгэнэ.
1.2 Богино хугацаат зээл	1721	2721	Харьяатын харьяат буст 1 жилээс богино хугацаатай олгосон зээлийг дебит, буцаан төлөгдөж буй зээлийг кредит талд бүртгэнэ.
1.3 Бэлэн мөнгө ба харилцах			Харьяатын гадаадын банкинд байршуулсан мөнгөн хөрөнгийг бүртгэнэ.
1.3.1 Банк			Харьяат банкуудын өөрийн ностро данснаас гадуур, гадаадын банкинд байршуулахаар шилжүүлсэн мөнгөн хөрөнгө буюу хадгаламжийг дебит, буцаан татсан хадгаламжийг кредит талд бүртгэнэ.
Урт хугацаат	1731	2731	1 жил ба түүнээс дээш хугацаатай байршуулсан
Богино хугацаат	1732	2732	1 жилээс богино хугацаатай байршуулсан
1.3.2 Бусад			Харьяат аж ахуй нэгж, иргэдийн гадаадын банкинд байршуулахаар шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг дебит, буцаан татсан гүйлгээг кредит талд бүртгэнэ.
Урт хугацаат	1733	2733	1 жил ба түүнээс дээш хугацаатай байршуулсан
Богино хугацаат	1734	2734	1 жилээс богино хугацаатай байршуулсан
<i>2. Пассив</i>			
2.1 Урт хугацаат зээл			<i>1 жил ба түүнээс дээш хугацаатай зээл</i>
Засгийн газар	1716	2716	Засгийн газрын харьяат бусаас авсан зээлийн ашиглалтыг кредит, зээлийг эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
Банкууд	1717	2717	Харьяат банкны харьяат бусаас авсан зээлийг кредит, зээлийг эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
ААН	1718	2718	Харьяат аж ахуйн нэгжийн харьяат бусаас авсан зээлийг кредит, зээлийг эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
Иргэд	1719	2719	Харьяат иргэний харьяат бусаас авсан урт хугацаат зээлийг кредит талд, зээлийг эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
2.2 Богино хугацаат зээл			<i>1 жилээс богино хугацаатай зээл</i>
Банкууд	1727	2727	Харьяат банкны харьяат бусаас авсан зээлийн ашиглалтыг кредит, зээлийг эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
ААН	1728	2728	Харьяат аж ахуйн нэгжийн харьяат бусаас авсан зээлийн ашиглалтыг кредит, эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
Иргэд	1729	2729	Харьяат иргэний харьяат бусаас авсан зээлийн ашиглалтыг кредит, зээлийг эргэн төлсөн бол дебит талд бүртгэнэ.
2.3 Бэлэн мөнгө, харилцах			Харьяат бусын харьяат банкинд байршуулсан мөнгөн хөрөнгийг бүртгэнэ.

2.3.1 Банк			Харьяат бус банкуудын харьяат банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө буюу хадгаламжийг кредит талд, буцаан татахад дебит талд бичнэ.
Урт хугацаат	1741	2741	1 жил ба түүнээс дээш хугацаатай байршуулсан
Богино хугацаат	1742	2742	1 жилээс богино хугацаатай байршуулсан
1.3.2 Бусад			Харьяат бус ААНБ, иргэдийн дотоодын банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө буюу оршин суугч бусын харилцах хадгаламжийн орох гүйлгээг кредит талд, буцаан татахад дебит талд утга харгалзахгүйгээр бичнэ.
Урт хугацаат	1743	2743	1 жил ба түүнээс дээш хугацаатай байршуулсан
Богино хугацаат	1744	2744	1 жилээс богино хугацаатай байршуулсан
ТУСГАЙ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ			
Буцсан гүйлгээ	1811	2811	Тодорхой шалтгааны улмаас гүйлгээг төлбөр шилжүүлэгч рүү буцаасан эсхүл түр дансанд орсон гүйлгээ.
Харьяат бус хоорондын дотоод гүйлгээ	1812	2812	Харьяат бусуудын дотоод дахь данс хооронд хийгдсэн гүйлгээг энэ дансанд бүртгэнэ.
Харьяат бусын дотоод гүйлгээ	1813	2813	Харьяат бусын гадаад валютын данс руу/данснаас хийгдсэн дотоод гүйлгээ.
Монголбанктай хийсэн гадаад валютын арилжаа	1814	2814	НОСТРО данс руу/данснаас Монголбанк дахь гадаад валютын данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Монголбанктай хийсэн төгрөгийн арилжаа	1815	2815	НОСТРО данс руу/данснаас Монголбанк дахь төгрөгийн данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Гадаадын банкны тайлагнагч банкин дахь гадаад валютын дансны гүйлгээ	1816	2816	Тайлагнагч банк дээрх харьяат бус банкны ЛОРС данс руу/данснаас тус банкны гадаад валютын данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Гадаадын банкны тайлагнагч банкин дахь төгрөгийн дансны гүйлгээ	1817	2817	Тайлагнагч банк дээрх харьяат бус банкны ЛОРС данс руу/данснаас тус банкны төгрөгийн данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Тайлагнагч банкны дотоодын өөр банкин дахь гадаад валютын дансны гүйлгээ	1818	2818	Банкны НОСТРО данс руу/данснаас тус банкны дотоодын өөр банкинд байрших гадаад валютын данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Тайлагнагч банкны дотоодын өөр банкин дахь төгрөгийн дансны гүйлгээ	1819	2819	Банкны НОСТРО данс руу/данснаас тус банкны өөр банкинд байрших төгрөгийн данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Банкны валютын болон төгрөгийн дансны бэлэн зузаатгал	1820	2820	Банкны НОСТРО данс руу/данснаас тус банкны Монголбанк дахь болон өөрийн валют, төгрөгийн данс руу хийсэн бэлэн арилжаа, зузаатгал.
Тухайн банкны өөрийн данс болон НОСТРО данс хооронд хийсэн арилжаа, зузаатгал	1821	2821	Банкны өөрийн банкин дахь данс руу/данснаас тус банкны НОСТРО данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.
Тухайн банкны НОСТРО данс хооронд хийсэн арилжаа, зузаатгал	1822	2822	Банкны НОСТРО данс руу/данснаас тус банкны өөр НОСТРО данснаас/данс руу хийсэн арилжаа, зузаатгал.

ОРНУУДЫН КОД

Дараалал	Орнууд	Код	Дараалал	Орнууд	Код
А	Австрали	AU	М	Мавритан	MR
	Австри	AT		Мавритани	MU
	Азербайжан	AZ		Мадагаскар	MG
	Албани	AL		Макао	MO
	Алжир	DZ		Македон (хуучин)	МК
	Америкийн Самоа	AS		Югославын Бүгд	
	Ангол	AO		Найрамдах Улс)	
	Андорра	AD		Малайз	MY
	АНУ	US		Мали	ML
	Арабын Бүгд	SY		Мальдив	MV
	Найрамдах Сири			Мальта	MT
	Арабын Нэгдсэн			Марокко	МА
	Эмират улс	Маршаллын арлууд			
	Аргентин	AR		Мексик	MX
	Армени	AM		Мозамбик	MZ
	Афганистан	AF		Молдав	MD
	Б	Балба		NP	Монако
Бангладеш		BD	Мьянмар	MM	
Барбадос		BB	Н	Науру	NR
Бахрейн		BH		Нигер	NE
Беларусь		BY	Нигери	NG	
Белиз		BZ	Нидерланд	NL	
Бельги		BE	Норвеги	NO	
Бенин		BJ	О	Оман	OM
Бермудын		BM		Оросын Холбооны Улс	RU
БНСУ		KR	Ө	Өмнөд Африк	ZA
Болгар		BG	П	Пакистан	PK
Болив		BO		Панам	PA
Босни-Герцеговин		BA	Папуа Шинэ Гвиней	PG	
Ботсван		BW	Парагвай	PY	
Бразил		BR	Перу улс	PE	
Бруней Даруссалам		BN	Польш	PL	
Буркина Фасо		BF	Португал	PT	
Бурунди		BI	Р	Руанда	RW
Бүгд Найрамдах		VU		Румын	RO
Вануату			Венесуэл (Боливарын	С	Самоа
В		Бүгд Найрамдах Улс нь)	Сан-Марино		SM
Вьетнам		VN	Саудын Араб	SA	
Г		Гайти	HT	Свазиланд	SZ
	Гамби	GM	Сейшелийн Арлууд	SC	
	Гана улс	GH	Сенегал	SN	
	Гваделуп	GP	Серби	RS	
	Герман	DE	Сингапур	SG	
	Гибралтар	GI	Словак	SK	
	Грек	GR	Словени	SI	
	Гүрж	GE	Солонгос (Ардчилсан	KP	
	Д	Дани	DK		Ард Улс)

Е	Египет	EG		Суринам	SR
Ж	Жордан	JO	Т	Тажикстан	TJ
З	Замби	ZM		Тайвань (Хятадын муж)	TW
	Зимбабве	ZW		Тайланд	TH
	Зүүн Тимор	TL		Танзани, Нэгдсэн Бүгд Найрамдах Улс	TZ
Й	Йемен	YE		Того	TG
И	Израиль	IL		Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	CF
	Индонез	ID		Тунис	TN
	Ирак	IQ		Турк	TR
	Иран (Исламын Бүгд Найрамдах Улс)	IR		Туркменстан	TM
	Ирланд	IE	У	Уганда	UG
	Исланд	IS		Узбекстан	UZ
	Испани	ES		Украйн	UA
	Итали	IT		Унгар	HU
	Их Британи	GB		Уругвай	UY
	Их Британийн Энэтхэгийн далайн нутаг дэвсгэр	IO	Ф	Фарерын арлууд	FO
К	Казахстан	KZ		Фижи	FJ
	Камбожийн	KH		Филиппин	PH
	Камерун	CM		Финлянд	FI
	Канад	CA		Франц	FR
	Капо Верд	CV		Францын Гвиней	GF
	Катар	QA		Францын Полинез	PF
	Кени	KE	Х	Хонг Конг	HK
	Кипр	CY		Хорват	HR
	Киргизстан	KG		Хятад улс	CN
	Колумб	CO	Ч	Чех	CZ
	Конго Улс	CG		Чили	CL
	Конго Улс (Бүгд Найрамдах Ардчилсан)	CD	Ш	Швед	SE
	Коста-Рика	CR		Швейцарь	CH
	Коте Д'Ивуар	CI		Шинэ Зеланд	NZ
	Куба улс	CU		Шинэ Каледони	NC
	Кувейт	KW		Шри-Ланка	LK
Л	Лаос Ард Улс Бүгд Найрамдах Ардчилсан	LA	Э	Эквадор	EC
	Латви	LV		Эль Сальвадор	SV
	Лесото	LS		Энэтхэг улс	IN
	Либерри	LR		Эстон	EE
	Ливан	LB		Этиоп	ET
	Литва	LT	Я	Япон	JP
	Люксембург	LU			

Бусад орнууд /тивээр/

Австрали тив	AUC
Ази тив	ASC
Америк тив	AMC
Африк тив	AFC
Европ тив	EUC

Гадаад гүйлгээний сарын тайлан
гаргах журмын Хавсралт №4

ХЯНАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Монголбанк		Банкны нэр:		
Хяналтын үнэлгээний хуудас		Тайланг сар:		
		Огноо:		
Шалгуур		Босго утга	Хувь	Тайлбар
Гүйлгээ бүрэн байх		1 сая ам.доллар		Гүйлгээг дутуу оруулсан байх нь статистик, судалгааны чандарт сөргөөр нөлөөлөх ноцгой зөрчил тул хүлээн зөвшөөрөгдөх босго утга нийлбэр дүнгээр 1 (нэг сая) сая ам.доллар байна.
Тайлангийн бүрэлдхүүн мэдээлэл бүрэн байх	Өндөр дүнтэй / > 200,000 ам.доллар /	< 2%		Гүйлгээний мэдээлэл дутуу оруулсан босго утга 200,000 (хоёр зуун мянга) ам.доллараас дээш дүнтэй нийт гүйлгээний 2%.
	Бусад	< 5%		Нийт бусад гүйлгээний 5%-иас дээш гүйлгээний мэдээллийг дутуу ирүүлэхгүй байх.
Тайлангийн бүрэлдхүүн мэдээлэл үнэн зөв байх	Өндөр дүнтэй / > 200,000 ам.доллар /	< 5%		Гүйлгээний мэдээлэл алдаатай байх босго утга 200,000 (хоёр зуун мянга) ам.доллараас дээш дүнтэй нийт гүйлгээний 5% байх.
	Бусад	< 15%		Нийт бусад гүйлгээний 15%-иас дээш гүйлгээний мэдээллийг алдаатай ирүүлэхгүй байх.
Гүйлгээний код зөв байх	Өндөр дүнтэй / > 200,000 ам.доллар /	< 5%		Гүйлгээний зорилгог болон бусад мэдээлэлд үндэслэн гүйлгээг зөв кодлох босго утга 200,000 (хоёр зуун мянга) ам.доллараас дээш дүнтэй нийт гүйлгээний 5% байх.
	Бусад	< 10%		Нийт бусад гүйлгээний 10%-иас дээш гүйлгээг буруу кодлохгүй байх.
Техникийн алдаа		Нийцгүй/нийцгүй		Журмаар батлагдсан тайлангийн форматыг дагаж мөрдөөгүй, гүйлгээний дүнг мянгахдаг.